

## СЭТГЭЛД ХОНОГШСОН ХОЁР ТОХИОЛДОЛ

БНМАУ-ын ардын жүжигчин, төрийн  
хошой шагналт **Б. Дамдинсүрэн**

Жараад оны үед БНХАУ-ын урлагийн талбарт гарсан хоёр сайхан үйл явдал миний сэтгэлд тод үлджээ. Миний сайн танил, төгөлдөр хуурч Лю Шикүнь өндөр нуруутай, Максим Горькийн залуу үеийнхтэй их төстэй, даруу төлөв зантай, дуу цөөтэй боловч урлагийн тухай ярихад ихэд сонирхдог залуу байсан. Москва хотноо болох Чайковскийн нэрэмжит төгөлдөр хуурчдын олон улсын уралдаанд оролцохоор Лю Шикүнь шаргуу сургууль хийж байхыг би үзсэн билээ. Хятад улсын олон сайн төгөлдөр хуурчныг төлөөлөн уг уралдаанд оролцоно гэдэг бол хариуцлагатай, нэр хүндтэй хэрэг байсан. Дэлхийн нэр цуутай төгөлдөр хуурчидтай авъяас чадлаа сорин тэмцэлдэх энэ хүн дорнодахинд төрж, дорнын соёлоор хүмүүжсэн байв. Өрнөдийн болон оросын сонгодог хөгжмийн зохиолын дотоод сэтгэлийн гүн агуулга, түүний өвөрмөц арга барил, ур чадварыг бүрэн эзэмшиж, олон арван жилийн турш тоглож байсан эдүй төдүй хөгжимчний ур чадалд бахдан биширч үе залган зүрх сэтгэлээрээ сонсож сурсан, хөгжмийн өндөр соёлтой үзэгч олны таашаалыг олно гэдэг амар даваа биш байсан. Түүнээс гадна уралдаан тэмцээнд олонтаа орж, ур чадвартай төгөлдөр хуурчдын тоглолтыг хянан шүүдэг шүүгчдийн анхаарлыг татах бэрх даваа бас байв. Энэ бүх хэцүү давааг Лю Шикүнь маш их тэсвэр хатуужил, шаргуу хөдөлмөр, авъяас чадвараараа даван туулж, уг уралдааны гуравдугаар байр эзэлсэн юм. Ийм сайхан амжилттай эх орондоо эргэж ирэхэд нь Хятадын урлаг соёлын зүтгэлтэн, хөдөлмөрчид, ялангуяа хөгжмийн зүтгэлтнүүд баяртай угтан авч, халуун баяр хүргэж байсан.

1960-аад оны үед Бээжин хотын үндэстний соёлын ордон хэмээх сүрлэг барилга баригдаж түүнд элдэв төрлийн үзэсгэлэн ажиллаж, олон нийтийн арга хэмжээ зохиогддог байв. Энэ ордны театрын тайзыг мялаасан нэг сайхан уран бүтээл гарсан нь бараг хятадын анхны гэж хэлж болох дэлхийн сонгодог бүжгэн жүжгийн үндсэнд зохиогдсон «Загасан дагина» хэмээх балет юм. Энэ нь ардын үлгэрт тулгуурласан бөгөөд сонгодог балетын үндсэн хэлбэрүүдийг бүрэн ашиглаж, түүн дээрээ үндэстний бүжиг наадмын хөдөлгөөнийг маш чадмаг хэрэглэж чадсан нь бүжиг дэглэгчдийн уран сэтгэмж сайн байсны тод илрэл юм. Уг бүжгэн жүжгийн тайзны зураг чимэглэлийг гайхам сайхан хийсэн байв. Энэхүү бүтээлийн гол амин сүнс болсон хөгжмийг Зү Чан, Ду Мэншин нар зохиосон юм. Бүжгэн жүжгийн эсрэг, эерэг дүрийн дотоод сэтгэлийг гүн гаргахдаа үндэстний ая аялгууны хэм хэмнэлийг олон янзын хэллэгээр товойлгон гаргаж чадсанаараа орчин үеийн Хятадын хөгжмийн урлагт шинэ хувь нэмэр оруулсан юм. Энэ бүжгэн жүжгийг хятадын олон мянган үзэгч төдийгүй гадаадын тойрон аялагч, зочид өндөр үнэлж байсныг үзээд Хятадын бүжгэн жүжгийн урлаг шинэ замаар хөгжин цэцэглэх нь зайлшгүй гэж бодож байснаа эргэн санахад сайхан байна.